

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1945 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 31 дүгээр хурлын тогтоол.

Аймаг, хотын захиргааны дэргэд төлөвлөгөөний хэлтсийг байгуулах тухай.

Улсын 28 дугаар Бага Хурлын тогтоолын ёсоор Ардын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

Нэг. Аймаг, хотын захиргааны дэргэд 2-3 хүний орон тоо бүхий төлөвлөгөөний хэлтсийг байгуулсугай.

Хоёр. Аймаг, хотын захиргааны дэргэдэх төлөвлөгөөний хэлтсийн дүрмийг баталсугай.

Гурав. Аймаг, хотын захиргаанаас тус тусын дэргэдэх төлөвлөгөөний хэлтсүүдийг зохих ажилтнаар хангаж, 1945 онд Улсын төлөвлөгөөний газраас эдгээр ажилтны ажлын агуудлын талаар богино хугацааны курсийг байгуулан ажиллуулсугай.

Дөрөв. Аймгийн төлөвлөгөөний хэлтэс нь аймгийн ханжсан даргад шууд харьяалагдана.

Ерөнхий сайд, улсын шалгарсан баатар, маршал  
Хэрэг эрхлэх газрын орлогч дарга

/ЧОЙБАЛСАН/

/ЖАМСРАН/

Эх материалаас цохисон Мандах.

эхийг  
Нийлсэн:  
лавлахыг

1968 - 5 - 9.

Аймаг, хотын захиргааны тэргүүлэгчдийн дэргэдэх төлөвлөгөөний хэлтсийн дүрэм.

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.

1.Төлөвлөгөөний хэлтсүүд аймаг, хотын захиргааны дэргэд байгуулагдаад түүний харьяанд багтаж, Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх төлөвлөгөө тоо бүртгэл ба хянан шалгах газарт харьяалагдан, аймаг орны /хотын/ аж ахуй ба соёл боловсролын төлөвлөгөөтэй холбогдсон бүх асуудлуудад түүний зааврыг удирдлага болгоно.

2.Аймгийн/хотын/захиргааны дэргэдэх төлөвлөгөөний хэлтсүүд нь аймаг, хотын захиргаанаас Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх төлөвлөгөө, тоо бүртгэл хянан шалгах газартай харилцан баталсан 2-3 хүмүүсээр байгуулагдана.

3.Аймаг, хотын захиргааны дэргэдэх төлөвлөгөөний хэлтсүүд нь төлөвлөгөөний хэлтсийн даргаар удирдуулна.

ХОЙР.ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭЛТСҮҮДИЙН ҮҮРЭГ ЗОРИЛГО.

1.Аймаг, хотын захиргааны дэргэдэх төлөвлөгөөний хэлтэс нь Засгийн Газраас баталсан тогтоол зааврыг баримтлан, аймаг орны аж ахуй ба соёл боловсролын төлөвлөгөөнүүдийг үйлдэх явдлыг эрхлэн удирдаж, төлөвлөгөөний биелэлтэд үргэлжийн хяналтыг тавьж шалгана.

2.Аймаг, хотын захиргааны дэргэдэх төлөвлөгөөний хэлтэс нь аймаг орны аж ахуй ба соёл боловсролын төлөвлөгөөнүүдийг үйлдэхдээ дор дурдсан зорилгуудыг үндэс болгоно. Үүнд:

а/Малын аж ахуйг зүйл бүрээр хөгжүүлэх, малын арчилгааг /малыг өвс бордоогоор хангах, малын ханаа сарагч барих, түүний чанарыг сайжруулах, худаг ус гаргах/ аль болохоор сайжруулах, малын эмнэлгийн ажлыг сайжруулах, малын аж ахуйд гарз хохирлыг учруулж байгаа чоныг авлаж устгах ажлыг хүчтэйгээр явуулах;

б/Хадлан, тариалангийн ажлыг ихээхнээр хөгжүүлэх ба ардын аж ахуйтантай нэг бүрийн малыг өвс бордоогоор хангахын тулд юуны өмнө хадлангийн ажлыг хөгжүүлэх, мөн элдэв цаг бусын зуд гачигт зориулж, баг бүрд өвсний фонд байгуулах;

в/Ард түмний өргөн хэрэглэхүүний бараа таварыг ихээхнээр нэмэгдүүлэн үйлдвэрлэж, улмаар ард олонд хүрэлцүүлэн нийлүүлэх зорилгоор орон нутгийн ресурс бэлтгэлийг аль болохоор ашиглаж үндсэн дээр аймаг орны үйлдвэрүүд/боловсруулах үйлдвэрүүд ба юуны өмнө гарын үйлдвэрийн дээд зөвлөл ба хүнсний үйлдвэрийн Яамны харьяа үйлдвэр/-ийг зүйл бүрээр хөгжүүлэх;

г/Улсын ямар нэгэн бэлтгэлийг цаг тухайд бүрнээ биелүүлэх, мал ба түүхий эдийг экспорт ба дотоодын хэрэгцээнд /үүнд боловсруулах ба хүнсний үйлдвэрүүдэд/цаг тухайд тууварлах ба тээвэрлэх;

д/Хөсөг тээврийг сайруулж, түүхий эдийг экспорт ба дотооны үйлдвэрүүдэд цаг тухайд саадгүй тээвэрлэх, мөн аймаг орны ард олны хэрэглэх бараа товаарыг тээвэрлэх явдлыг хангах;

е/Соёл боловсролыг хөгжүүлэх, юуны өмнө аймаг орны ард олныг сургуулиудад ба гэрээр бичиг үсэгт сургах, мөн клуб, улаан гэр зэргүүдийг хөгжүүлэх эдгээр болно.

Гурав. Төлөвлөгөөний хэлтсүүдийн  
эрх үүргийн тухай

1. Аймаг, хотын захиргааны дэргэдэх төлөвлөгөөний хэлтэс нь Засгийн Газраас гарсан тогтоол зааврыг баримтлан, сумд нэг бүрийн төлөвлөгөөнүүдийг хийх явдлыг эрхлэн удирдаж уул төлөвлөгөөг улмаар аймаг, хотын захиргаадад батлуулахаар оруулна.

2. Аймаг, хотын захиргааны дэргэдэх төлөвлөгөөний хэлтэс нь аймаг орны аз ажуй ба соёл боловсролын төлөвлөгөөнүүдийн биелэлтэд цаг ямагт хяналт шалгалтыг тавьж байх үүнд:

а/Аймаг, сум ба багуудын төлөвлөгөөг арга хэмжээнүүдийн биелэлтийг шууд шалгах, тухайн дүнг аймаг, хотын захиргаадад мэдэгдэх;

б/Төлөвлөгөөг ажлуудын талаар сумын захиргаад ба аймгийн байгууллагуудаас зохих тайлан мэдээнүүдийг гаргуулан авч, улмаар аймаг, хотын захиргаадад ирүүлж байх.

3. Аймаг, хотын захиргааны дэргэдэх төлөвлөгөөний хэлтсүүд нь төлөвлөгөөнүүдийн биелэлт ба Засгийн Газар хийгээд аймаг, хотын захиргааны зарим тогтоолуудын биелэлтийг шалгахад хэрэглэгдэх материалууд ба тайлбаруудыг аймаг, хотын байгууллагууд, сум, багийн захиргаадаас шаардан авах эрхтэй болно.

4. Аймаг, хотын захиргааны дэргэдэх төлөвлөгөөний хэлтсүүд нь төлөвлөгөөнүүдийг хийх ба биелэлтийг шалгах тухайн материалуудыг авах талаар аймгийн байгууллагуудтай шууд харилцах эрхтэй болно.

5. Аймаг, хотын захиргааны дэргэдэх төлөвлөгөөний хэлтсүүд нь аймаг хотын аз ажуй ба соёл боловсролын төлөвлөгөөнүүд болон түүний биелэлттэй холбогдсон бүх материалуудыг Сөйд нарын Зөвлөлийн дэргэдэх төлөвлөгөө тоо бүртгэл хянан шалгах газраас тогтоосон маяг ба хугацаануудад мөнхүү газарг ирүүлж байх үүрэгтэй болно.

62

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1945 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 31 дүгээр хурлын тогтоол.

Утга нь: Эрүүлийг Хамгаалах Намны харьяа  
байгууллагуудын санхүү-аж ахуйн амилла-  
гааны тухай.

Эрүүлийг Хамгаалах Нам, Улсын төв эмнэлэг, Нактер шинжилгээний газар, нялхсын комбинат, Сайд нарын Зөвлөлийн эмнэлэг, Нүхтийн ашны амралт, тарав-  
ган тахлыг эсэргүүцэх станц, эмнэлгийн техникум, хотын хүн эмнэлгийн хэлтэс  
Улаанбаатар хотын эмнэлгүүдийн 1943 ба 1944 оны санхүү, аж ахуйн амилла-  
гааг шалган байцаасан дүнгийн тухай Сангийн Намны сайд н.Бямбаагийн  
илтгэлийг сонсоод Сайд нарын Зөвлөлөөс Тэмдэглэх нь:

Эдгээр нэр бүхий байгууллагуудын ажлыг шалган байцаахад хяналт шал-  
галт ба харцуцлагагүй байдал илрэв. Төсөв, орон тооны сахилгыг сүрхийгээр  
гажуудуулж, төсөвлөсөн хөрөнгийг зохих зүйлд нь зарцуулахгүй явдал олонтой  
үзэгддээ. Эмч нар ба эмнэлгийн бусад ажилтны хавсран амилласны амиллагааг  
хураантай болгоогүй/7 хоногт 9 ба 20 цаг хавсран амилладаг эмч нар нь  
нэгэн адил 40 хувийн цалинг авч буй/Эрүүлийг Хамгаалах Намаас эмнэлэг  
ба амбулаторийн ажилтны амиллах цаг ба ашны нормыг одоо хүртэл тогтоо-  
гоогүй, мөн хөдөлмөрийн сахилгыг сүрхийгээр гажуудуулах явдал үзэгдэх  
байна. Зарим шалган байцаасан газруудын ажилтанд хоол унд ба аж ахуйн  
хангалтыг зүй бусаар үнэ төлбөргүй олгож, мөн нэр бүхий байгууллагуудаас  
түлээ түлшийг цаг тухайд нь бэлтгэхгүйгээр үл барам, харин түлээ бэлтгүүл-  
сний хөлсөнд идэш уушийн зүйл ба бараа төваарыг хууль бусаар олгох явдал  
олонтой үзэгддээ.

Эрүүлийг Хамгаалах Намны харьяа шалгагдсан байгууллагуудын ихэнх нь  
үнэ бүхий эд хогийн гүйлгээ, идэш уушийн зүйл ба мөнгө хөрөнгүүдийг хү-  
лээн авах ба зарцуулах явдалд ямар ч бүртгэлгүй, эмх замбараагүй байлга-  
сан нь эд материалын үнэ бүхий зүйлүүдийг үлэмжхэнээр дутагдуулж, түүнийг  
хулгайлсан үрэгдүүлэх байдалд хүргэв. Эрүүлийг Хамгаалах Намны харьяа бай-  
гууллагуудын санхүү, аж ахуйн амиллагааг нэгцэтгэн сайжруулж, шалган бай-  
цаалтаар илэрсэн дутагдлуудыг арилган засах зорилгоор Сайд нарын  
Зөвлөлөөс ТОГТООХ нь:

Эрүүлийг Хамгаалах Намны сайд нийийнэнд үүрэг болгон, гүйцэтгэх арга  
хэмжээнүүдийг дурдвал:

1. Эмнэлэг ба амбулаторийн байгууллагуудын ашны хүнд, хөнгөн, хортой,  
хоргүй байдлыг харгалзан, эмнэлгийн ажилтны өдөр тутам амиллах цагийг  
тогтоох тухайн төлөвлөгөөг 2 долоо хоногийн дотор боловсруулан, Сайд на-  
рын Зөвлөлд оруулан батлуулуугай.

2. Эмнэлгийн ажилтны хөдөлмөрийн зохион байгуулалтыг нэгэн сарын  
дотор хянан үзэж, ард олонд үзүүлэх эмнэлгийн тусламжийг сайжруулах ба

эмнэлгийн ажилтны хөдөлмөрийн хөлсийг журамтай болгох зорилгоор эмнэлгийн ажилтныг ажил дээр нь зөвөөр зохион байгуулж, ажиллуулсугай.

3. Засгийн Газраас хавсарсан гүйцэтгэх ажлын тухай гаргасан тогтоолд тохируулан, эмч нарын хавсарсан ажиллагааны хөлсийг журамтай болгосугай.

4. 1945 онд улсын төв эмнэлэг, нилхсын комбинат, хий судлын эмнэлэг, эдгээр аж ахуйн төсвийг зохиож, түүний эд хогшлын байдал ба зарцуулалтыг нарийн чанга бүртгэлтэй байлгасугай.

5. Эмнэлгийн ажилтнаас илүү цаг ажилласан ба мөн сайн өдрүүдэд ажилласны хөлс болон бас идэш уушийн зүйл ба аж ахуйн хангалтыг үнэ төлбөргүйгээр олгох явдлыг энэ талаар дагаж шийтгүүлэн байгаа куульд нийлүүлэн, журамтай болгосугай.

6. Эмнэлгийн ажилтнаас хөдөлмөрийн сахилга батыг санаатайгаар зөрчилдөг хуумийн хариуцлагыг хүмээлгэх хүртэл хамгийн шийдвэртэй арга хэмжээ авч, хөдөлмөрийн сахилга батыг дээшлүүлсүгэй.

7. Эмнэлгийн байгууллагуудаас нэгэн жилд хэрэглэх түлшээ цаг тухайд бэлтгэн татаж авах ажлыг хангасугай.

8. Аливаа нэгэн ажлын хөлсийг идэш уушийн зүйл ба бараа товаараар төлдөг явдлыг шууд зогсоосугай.

9. Ажлын малыг худалдсан ба эд материалыг дутагдуулсан хийгээд идэш уушийн зүйлийг үрэгдүүлэгчдэд хариуцлага хүлээлгэхийн тулд нэгэн сарын дотор холбогдох материалыг шүүх таслах газар шилжүүлсүгэй.

10. Улсын төсөвт бүх байгууллагуудаас нэгэн сарын дотор мөнгөн хөрөнгө, эд хогшил, идэш уушийн зүйл зэрэгийг мөнгөн хэл дээр нягтлан бодохыг бүртгэлтэй болгож, тэдгээр байгууллагуудаас эд материалын гүйлгээ ба мөнгөн хөрөнгийн амиглалтын талаар тайлан мэдээг Эрүүлийг Хамгаалах Яамны өмнө заавал гаргуулж байх ажлыг зохион байгуулахаас гадна энэ талаар Эрүүлийг Хамгаалах Яаманд бүхийл аргаар туслаж байхыг Сангийн Яамны сайд н. Бямбаад үүрэг болгосугай.

11. Сангийн Яамтай хамтран гүйцэтгэх үүргийн дурдвал:

а/ Улаанбаатар хотын эмнэлгийн байгууллагуудад ажиллуулахаар 20 тооны дансны ажилтны 3 сарын курсээр энэ онд бэлтгэн гаргах ба шалган байцаагч нарын орон тоог энэ оны 7 дугаар сарын нэгний наана хангасугай

э/ Мөнгөн хөрөнгө ба эд материалын бүртгэлийг хөтлөх ба мөн татварыг суутгах ажлын талаар Улаанбаатар хотын эмнэлгийн байгууллагуудын нягтлан бодох нарын давтан семинарыг энэ оны 5-6 дугаар сарын турш явуулсугай;

12. Улсын төв эмнэлэгт эзэнгүй болсон эд хөрөнгийг илрүүлэн бүртгэлтэй болгохын тулд Сангийн Яамны төлөөлөгчийг оролцуулсан комиссыг чин даруй байгуулахаас гадна эд хөрөнгийг хамгаалах ба хууль ёссор эзэмшвэл зохих хүмүүсийг илрүүлэн олох талаар арга хэмжээ авчхэрвэ

гийн хүмүүс байхгүй бол уул хөрөнгийг жинхэнэ эзний нь нас нөгчсөнөөс хойш 6 сарын турш хадгалсаны дараагаар улсын фондод шилжүүлж байсугай.

13. Сайд нарын Зөвлөлийн 1943 оны 12-р сарын 3-ны өдрийн 81 дүгээр хурал ба мөн 1944 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 87 дугаар хурлын тогтоолууд болон, бас ерөнхий сайдын нэгдүгээр орлогч сайдаас 1944 оны 9-р сарын 12-ын өдөр гаргасан тушаалыг биелүүлэн гүйцэтгээгүй ба мөн түүнчлэн Эрүүлийг Хамгаалах Яамны харьяа байгууллагуудын аж ахуй, санжүүгийн ажиллагааг удирдах талаар санаа амаржингүй суусан учир эмнэлгийн байгууллагуудын санхүү, аж ахуйн ажиллагааг шууд хариуцах үүрэг бүхий Эрүүлийг Хамгаалах Яамны орлогч сайд н.Тувааныг донгодоугай.

14. Энэхүү тогтоолын гүйцэтгэлийн дүнгийн тухай Эрүүлийг Хамгаалах Яамны сайд н.Ийнэнтийн илтгэлийг 1945 оны 3 дугаар сард Сайд нарын Зөвлөлийн хурлаар сонссугай.

- 3. Улаан сайд
- 4. Улаан Ерөнхий сайд, улсын шалгарсан
- 5. Зохио баатар, маршал /ЧОЙБАЛСАН/
- 6. Сайн Хэрэг эрхлэх газрын дарга /БАТ-ОЧИР/

15. Эрүүлийн хурал

16. Эрүүлийн хурал

17. Эрүүлийн хурал

18. Эрүүлийн хурал

19. Эрүүлийн хурал

20. Эрүүлийн хурал

21. Эрүүлийн хурал

22. Эрүүлийн хурал

23. Эрүүлийн хурал

24. Эрүүлийн хурал

25. Эрүүлийн хурал

26. Эрүүлийн хурал

27. Эрүүлийн хурал

28. Эрүүлийн хурал

29. Эрүүлийн хурал

30. Эрүүлийн хурал

Эрүүлийн хурал

Хэрэг эрхлэх газрын дарга

Хэрэг эрхлэх газрын дарга